



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02-р сарын 04-ны өдөр

№ 25/06

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дах заалт, Компанийн Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулах журмын 6.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 01 дугаар сарын 30-ны өдрийн А/07 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зэргэлдээ компани болох “Инвескор Пропери” ХХК-тай Компанийн өмчлөлийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж, Ай Си Тауэр барилгын 14 давхарт хөрөнгийн менежментийн үйлчилгээ авах зорилгоор доорх нөхцөлөөр “Байгууламжийн менежментийн гэрээ” байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:

Гэрээний хугацаа: 2025.01.01-ний өдрөөс эхлэн 2025.12.31-ний өдрийг дуустал
1 сарын менежментийн төлбөр: 1 м.кв тутамд 9,900 төгрөг

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах, Байгууламжийн менежментийн гэрээнд компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Ч. ХАШЧУЛУУН

Д. ЭНХБАТ

Ч. ӨНӨРЖАРГАЛ

Т. ТЭЛМЭН